



“ДУНДГОВЬ АЙМГИЙН БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН”  
“ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ”  
ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ

*Нэг. Зорилго:*

Орон нутгийнхаа боломж, давуу талыг ашиглан хэрэглэгчийн таашаалд нийцсэн бахархал болохуйц чанар сайтай, өрсөлдөх чадвар бүхий брэнд, шилдэг бүтээгдэхүүнийг шалгаруулан дэмжин урамшуулж улмаар бүс нутаг, улсын хэмжээнд борлуулан экспортод гаргах, гадаад, дотоодын зах зээлд байр сууриа эзлэх шинэлэг бараа бүтээгдэхүүн үйлчилгээг бүрдүүлэхэд түлхэц өгөхөд оршино.

*Хоёр. Хамрах хүрээ, хугацаа:*

Үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээгээ сурталчлах, борлуулах, үйлчилгээ үзүүлэх, харилцан туршлагаа солилцох, бизнесийн мэдээлэл олж авахыг хүссэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчидэд нээлттэй оролцоно.

“Дундговь Түншлэл-2024” үзэсгэлэн худалдаа нь “Говийн өнгө” нэртэйгээр 09 дүгээр сарын 13-15-ны өдрүүдэд төв цэнгэлдэх хүрээлэнд болно.

*Гурав. Шалгаруулах шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээний номинаци:*

1. Шилдэгийн шилдэг “Гран при”-1
2. Шилдэг сүү сүүн бүтээгдэхүүн -3
3. Шилдэг газар тариалангийн бүтээгдэхүүн -2
4. Шилдэг аж үйлдвэрийн бүтээгдэхүүн -1
5. Шилдэг гар урлал үйлдвэрлэгч -1
6. Шилдэг хүнсний бусад нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч- 1
7. Шинэ бүтээгдэхүүн, шинийг эрэлхийлэгч иргэн -1
8. Шилдэг хоол үйлдвэрлэгч - 1
9. Шилдэг сум-3
  - шилдэг зохион байгуулалттай сум
  - шилдэг үйлдвэрлэгчтэй, хамгийн их борлуулалттай сум
  - Шинэ брэндинг бий болгосон сум

Дөрөв:Шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээний номинаци шалгаруулах шалгуур үзүүлэлт

№	Бүтээгдэхүүний номинаци	Тоо ширхэг	Шалгуур үзүүлэлт
1	шилдэгийн шилдэг "Гран при"	1	Зах зээлд танигдсан эсэх /Эрэлт нийлүүлэлтийн харьцаа/ Бусдаас ялгарах онцлог Үйлдвэрлэлийн тогтвортой байдал Ажлын байрны тоо Нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлсэн, оролцсон байдал
2	шилдэг айраг үйлдвэрлэгч өрх	1	<b>Айраг MNS 4229:2011</b> -Уураг 2%-аас багагүй -Тослог 1,7%-оос багагүй -Исгэлэн 90-125 тернер -Шинж чанар /жигд шингэн биет байдалтай, өвөрмөц сэнгэсэн амттай, сүүн цагаан өнгөтэй, илт мэдэгдэхүйц туналтгүй байх/ Малчин өрхийн тамгаар баталгаажуулсан шошигтой байх <i>/Дээжинд өгөх хэмжээ 2 литрээс хэтрэхгүй байх/</i>
3	шилдэг сүүн бүтээгдэхүүн үйлвэрлэгч	2	-Бүтээгдэхүүнд тавигдах стандарт, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан эсэх -Сав баглаа боодол, хаяг шошготой эсэх - Бүтээгдэхүүний нэр төрлийн тоо, өнгө үзэмж, амт чанарт гарсан ахиц өөрчлөлт <b>Аруул, хурууд MNS 4230:2005</b> -Чийглэг-35%-аас багагүй -Уураг 30-40% -Тослог 05-30% -Чихэрлэг 2-30% -Исгэлэн 180-270 тернер -Өнгө /жигд цагаанаас бор шаргал/ -Амт, үнэр /нэр төрөлдөө тохирсон исгэлэндүү эсвэл чихэрлэг амттай, өөрийн өвөрмөц үнэртэй/ <b>Эзгий MNS 4230:2005</b> -Чийглэг-35% аас багагүй -Уураг 20-30% -Тослог 7-30% -Өнгө /цагаан шаргалаас улаан шаргал/ -Амт, үнэр, биет байдал /бага зэрэг чихэрлэг амттай, өөрийн өвөрмөц үнэртэй, зөөлнөөс хатуу биет байдалтай/
4	Шилдэг газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	2	Орон нутгийн хөрсөнд тариалсан байх Тарьж ургуулсан ногооны нэр төрөл тоо Хураан авсан ургацын хэмжээ
5	Шилдэг аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	1	Зах зээлд танигдсан эсэх /Эрэлт нийлүүлэлтийн харьцаа/ Бусдаас ялгарах онцлог Үйл ажиллагааны тогтвортой байдал
6	Шилдэг гар урлал үйлдвэрлэгч	1	Үйл ажиллагааны тогтвортой байдал Бүтээгдэхүүний загварын өөрчлөлт Борлуулалтын орлого
7	Шилдэг хүнсний бусад нэрийн	1	Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага MNS 6648:2016 стандартын шаардлага хангасан эсэх

	бүтээгдэхүүн үйлдвэрлэгч		Зориулалтын сав, баглаа боодол, Шинэ санаа, шинэ технологи, шинэлэг бүтээгдэхүүн нэвтрүүлсэн эсэх
8	Шинэ бүтээгдэхүүн, шинийг эрэлхийлэгч иргэн	1	шинэлэг бүтээгдэхүүний нэр төрлийн тоо Зах зээлийн эрэлт хэрэгцээ шинэ технологи, шинэлэг бүтээгдэхүүн нэвтрүүлсэн эсэх
9	Шилдэг хоол үйлдвэрлэгч	1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлын хэрэгжилт Зориулалтын халуун барих болон битүүмжлэл бүхий тагтай сав баглаа боодол ашигласан эсэх Хоол ундааны нэр төрөл амт чанар өнгө үзэмж, чимэглэл Борлуулалтын орлогын хэмжээ Үйлчлүүлэгчдийн ая тухыг хангасан орчин бүрдүүлсэн эсэх Ажлын хувцсыг бүрэн өмссөн байх Технологийн карт хөтөлж ил байршуулсан байх
	Шилдэг сум-3		
	Шилдэг зохион байгуулалттай сум	1	Сумын онцлог хэв шинжийг тусган сурталчилж оролцсон байдал Уг арга хэмжээнд ач холбогдол өгч оролцож буй байдал /нэгдсэн зохион байгуулалт, хаяг, лого, хувцаслалт, цагийн менежмент, орчны цэвэрлэгээ, эрүүл ахуй/
10	Шилдэг үйлдвэрлэгчтэй, хамгийн их борлуулалттай сум	1	Оролцогчийн тоо, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, борлуулалтын орлого /мэдээг өдөр өдөрт гаргаж ирүүлэх/
	Шинэ брэндиг бий болгосон сум	1	Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүний тоо /Тусгай танилцуулгатай байх/ Зах зээлд танигдсан эсэх шинэ технологи, шинэлэг бүтээгдэхүүн нэвтрүүлсэн эсэх Борлуулалтын орлогын хэмжээ

*Тав. Уралдааны шалгаруулалт*

Шалгаруулалтад оролцох иргэн, аж ахуй нэгж нь өрсөлдөж буй номинацийн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан үйлдвэрлэлийн танилцуулгыг ажлын хэсэгт ирүүлнэ.

Шалгаруулалтад орох бүтээгдэхүүний дээжийг 2024 оны 09 дүгээр сарын 13-ны 12-17 цагийн хооронд хүлээн авна.

Дээрхи шалгуур үзүүлэлтийн дагуу шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээг 1-5 баллаар дүгнэнэ.

Ерөнхий дүнг гаргахдаа дэд ажлын хэсгийн хүмүүсийн өгсөн онооны дундажаар бодож гаргана.

Зургаа. Шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээний шагналын сан:

Шилдэгийн шилдэг “Гран при” Өргөмжлөл 800.000 төгрөг

Шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч *номинаци* тус бүр Өргөмжлөл 500.000 төгрөг

Шилдэг сум тус бүр 2.0 сая төгрөг

АЖЛЫН ХЭСЭГ